

**“Шарынгол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдуулан**

**хийгдэх ажил, цаг хугацааны графикин дагуу хийсэн ажлын гүйцэтгэл**

**2016.04.25**


<b>1</b>	<ul style="list-style-type: none"><li>- Компанийн ТУЗ-ийн 2016 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хуралд ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудал хэлэлцэж 05 дугаар тогтоол гаргасан. Холбогдох шийдвэрийг ХЭ-ийн ээлжит хуралд дэлгэрэнгүй мэдээлнэ.</li></ul>
<b>2</b>	<ul style="list-style-type: none"><li>- “Ногдол ашгийн тухай” тогтоолыг СЗХ, МХБ-д төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн №10 албан бичгээр хүргүүлсэн.</li></ul>
<b>3</b>	<ul style="list-style-type: none"><li>- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай асуудлыг ТУЗ-ийн 2016 оны 03 дугаар сарын 11-ний хуралд хэлэлцэж” Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” 07 дугаар тогтоол гаргасан.</li></ul>
<b>4</b>	<ul style="list-style-type: none"><li>- “Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай” ТУЗ-ийн шийдвэр бүхий мэдэгдэл, / хавсралт Зш/ нийт 7 хуудсыг 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн №12-ооп СЗХ, МХБ-д хүргүүлсэн.</li></ul>
<b>5</b>	<ul style="list-style-type: none"><li>- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг МХБ болон өөрийн вэб сайтад байрлуулсанаас гадна “Өдрийн сонин”-ны 2016 оны 3 дугаар сарын 16-ны 061 дугаар, “Өнөөдөр сонин”-ны 2016 оны 060 дугааруудад хэвлүүлж нийтэд мэдээлж эхэлсэн.</li></ul>
<b>6</b>	<ul style="list-style-type: none"><li>- Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2016 оны 3 дугаар сарын 26-наар гаргуулахаар “ҮЦТТТХТ” ХХК-д, 2016 оны 3 дугаар сарын 28-ны №14 албан бичиг хүргүүлсэн. “ҮЦТТТХТ” ХХК-ийн ирүүлсэн бүртгэлийг 26-ны өдөр, амралтын өдөр тул 25-ны өдрөөр гаргаж ирүүлсэн болно.</li></ul>
<b>7</b>	<ul style="list-style-type: none"><li>- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг “Өдрийн сонин”-ны 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн №076, “Өнөөдөр сонин”-ны 2016 оны 4 дүгээр сарын 1-ний №075 дугааруудаар давтан гаргасан.</li></ul>
<b>8</b>	<ul style="list-style-type: none"><li>- ХЭХ-ын хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, тайлан бүхий материалыг товхимол болгон монгол, англи хэлээр хэвлүүлж харьяа брокер диллерийн компаниудад саналын хуудасны хамт 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс хүргүүлж ХЭ-ийн санал урьдчилан өгөх бололцоогоор хангасан. Мөн компанийн засаглалын үндэсний портал сайтад бүрэн эхээр нь оруулсан.</li></ul>
<b>9</b>	<ul style="list-style-type: none"><li>- Жилийн үйл ажиллагааны тайлан, “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний агуулга” бүхий маягтын асуулгад хариулж МХБ-д хугацаанд нь хүргүүлсэн.</li></ul>
<b>10</b>	<ul style="list-style-type: none"><li>- Жилийн эцсийн санхүүгийн тайлан / аудитлагдаагүй/ -г 2016.02.18-ны 09 тоот албан бичгээр СЗХ, МХБ-д хүргүүлсэн.</li></ul>
<b>11</b>	<ul style="list-style-type: none"><li>- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулийн хугацаа буюу 2016.04.25-нд төлөвлөсөн хугацаанд хуралдуулж байна.</li></ul>

12	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлан бүхий материал , хурлын шийдвэр, саналын хуудасны хуулбар зэргийг хурлаас хойш ажлын З хоногт багтааж СХЗ, МХБ-д хүргүүлнэ.
13	- ХЭХ-ын хурлын тухай мэдээллийг МХБ болон өөрийн вэб сайтад байршуулна.

Ажлын гүйцэтгэлийг гарган бичиж

ХЭХ-д оролцогчдод мэдээлсэн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: ..... Л.Батсуурь/



## **“Шарынгол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдээлэл**

2016.04.28

“Шарынгол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр “Баянгол зочид буудал”-ын хурлын танхимд хуралдав.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10.170.242 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж 9.539.097 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа буюу 93.79% нь санал ирүүлсэн байна.

Хуралд:

- Компанийн 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажил, засаглалын тайланг батлах.
- Компанийн ТУЗ-ийн 2016 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
- Компанийн 2015 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл.

Дээрх 3 асуудлыг хэлэлцэж 1, 2 дугаар асуудлын шийдвэрийг тогтоолоор баталлаа. 3 дугаар асуудал мэдээлэл байсан.

Хуралд хэлэлцсэн асуудлаар санал хураалтын дүнг танилцуулбал:

1 дүгээр асуудалд 9.539.095 ширхэг энгийн хувьцаагаар “**Зөвшөөрсөн**” санал буюу 100% .

2 дугаар асуудалд 10 ширхэг энгийн хувьцаагаар “**Татгалзсан**” санал, 9.539.085 ширхэг энгийн хувьцаагаар “**Зөвшөөрсөн**” санал буюу 100% - ийн санал тус тус өгсөн байна.

3 дугаар асуудал /мэдээлэл/-аар санал хураагаагүй болно.

Ногдол ашиг хуваарилахгүй үндэслэл нь 2015 онд нүүрс олборлолт борлуулалт төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй. Учир нь, эдийн засгийн байдлаас шалтгаалан нүүрс борлуулах зах зээл хомсдосноор 450,0 сая орчим төгрөгийн алдагдалтай ажилласан. Иймээс компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 8 дахь заалтыг үндэслэн ТУЗ-ийн хурлаар ийм шийдвэр гаргасан гэж танилуулсныг мэдээлж байна.

**Хурал зохион байгуулах комисс**

**Харилцах Утас: 976-11-311073, 99293913, 99031917**

**Электрон шуудан: otgonzul@sharyngol.com**